

МАТАД СУМЫН ЕБС-ИЙН 8-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Гүйцэтгэх хугацаа- 60 минут

Нийт оноо 20

Сурагчийн нэр.....

А хувилбар

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ
УНШИХ ЧАДВАР СОРЬСОН ДААЛГАВАР [20 оноо]

Санамж: Эхийг анхааралтай уншиж ойлгоод асуултад хариулаарай.

ЛИМБИЙН ЭГШИГ

Хөхнүдэнгийн лимбийн эгшиг толгод дамжин чичирхийлсээр сэтгэл гижигдэнэ. Лимбийн эгшиг даган Онгоны цагаан хялгана талын энгээрээ салхи номхорно.

Хөхнүдэн гэж хөгийн эр бий. Мунхаг юмуу гэтэл ухаантай ч юм шиг. Ухаантай юм уу гэхлээр будлиу ч юм шиг. Яах аргагүй айл хотлоороо хэсэж, алаг лимбээ цангинуулан бор ходоодоо болгоно.

“Хүрэн толгойн сүүдэр хөндийгээ дагаад хүүшилнэ” гэсэн ээдрээ хүрэн аялгуу толгод дамжин тооноор дотогшлох үес хүүхнүүд үс зүсээ янзлан, тогоо гал хоёроо залгуулна. Хөхнүдэнг хүлээж авах гэж байгаа нь тэр.

Лимбийн эгшиг ойртоно. Хүүхнүүд галдаа аргал нэмсээр...

“Хүрэн толгойн сүүдэр хөндийгээ дагаад хүүшилнэ...” Хөөрхий дөө, Хөхнүдэн өнөөхөө л үлээж явна.

Тэр энэ дуугаараа бусдыг халтартуулахаас цаашгүй. Харин “Хүрэн толгойн сүүдрээ”-ээ бол ч ус шиг цэнхэртүүлж гарна даа. Уян хүний нулимс урсахдаа л урсана.

Сумын даргаа сууж угтдаг улс чинь Хөхнүдэнг болохоор хөл алдан хөөрцөглөж уяан дээр түшиж буулган сугадан мордуулна. Хөхнүдэн хааяа балгана. Балгахаараа уйлна. Уйлж байгаад лимбэднэ. “Ийгиймаа намайг зовоогоогүй болч энэ бид хоёр ингэж явахгүй л дээ” гэсээр хулсан лимбээ хуруугаараа илбэж, зузаан уруулаа шүлэмдэж байгаа аялгуу цацраан “Хүрэн толгойн сүүдэр” биднийг нөмрөөд авна.

Тэр сүүдэр Хөхнүдэнгийн сэтгэлд унасан сүүдэр болохыг мэдэхийн учир хоолой зангирна. Хөөрхий дөө хөх тэнгэрийн дор зовж л яваа хүний үр.

“Та нар намайг биш лимбийг минь л тоож байгаа юм” гэж агсамнах гоморхохын завсарт үглэнэ. Ямар юмных нь агсам байхав дээ. Ийм хүн агсамнадаггүй юм.

Лимбийн эгшиг шуранхайлан Онгоны цагаан хялгана намс, намс бөхөлзөнө. Айл болгоны гал дээр цай даргилан, Хөхнүдэн гадаалж дөрөө мултлахыг хүлээнэ.

Ид шидээр өртөөлсөн лимбийн эгшиг тоонотой болгоны тооноор дотогшлон бууж гал сэтгэл хоёрыг дүрэлзүүлнэ.

Ийм л нэг хүний үр байв даа, дэлгээ цагаан Онгонд.

С.Пүрэв

1. Эхийн гол санааг илэрхийлж бичнэ үү. /2 оноо/

.....
.....

2. Дараах үгсийн утгыг тайлбарлана уу. /2 оноо/

Нар хүүшлэх:

Сэвшээ салхи:

3. Лимбэний амьдчилсан буюу хүний хийдэг үйлийг хийж байгаа жишээг эхээс олж бичээрэй. /2 оноо/

.....
.....
.....

4. Дээрх эхэд байгаа “хөл алдах” хэмээх хэлц нь ямар утгатай вэ. Тайлбарлан бичнэ үү. /2 оноо/

.....
.....

5. Хөхнүдэнг айл хотлынхон нь хүлээж авах гэж байгааг илэрхийлсэн өгүүлбэрийг эхээс олж бичээрэй. /2 оноо/

.....
.....
.....

6. Зохиолыг гол дүртэй нь зөв харгалзуулаарай.

- | | |
|--------------------------------------|---|
| 1. “Далан худалч” \хошин жүжиг\ | а. Цэвэгдорж, Жанцан, Лодойсамбуу, Сэмбэн |
| 2. “Усны эргүүлэг ба борзооны явдал” | б. Нямаа, Жамьяан, жаал хүү, их хүү |
| 3. “Үрэгдсэнийг хүлээгч” \өгүүллэг\ | в. Сэнгээ, Алимаа, Давст, Пагма |
| 4. “Шидэт хүүрийн үлгэр” | г. Полифем, Хэнчбиш, Циклоп, Перимед |
| 5. “Одиссей” \их туульс\ | д. Илбэчин, багш, хүү, эмгэн, өвгөн |

7. Дараах үндэсний бичгийг уншаад кирил бичигт хөрвүүлнэ үү. /5 оноо/

| | |
|---|--|
| ᠮᠣᠩᠭᠡᠨᠢ ᠶᠡᠨᠢᠨᠠᠨᠢ ᠶᠡᠨᠢᠨᠠᠨᠢ ᠶᠡᠨᠢᠨᠠᠨᠢ ᠶᠡᠨᠢᠨᠠᠨᠢ ᠶᠡᠨᠢᠨᠠᠨᠢ ᠶᠡᠨᠢᠨᠠᠨᠢ ᠶᠡᠨᠢᠨᠠᠨᠢ | |
|---|--|

МАТАД СУМЫН ЕБС-ИЙН 8-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Гүйцэтгэх хугацаа- 60 минут
Сурагчийн нэр.....

Нийт оноо 20

Б хувилбар

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ
УНШИХ ЧАДВАР СОРЬСОН ДААЛГАВАР [20 оноо]

Санамж: Эхийг анхааралтай уншиж ойлгоод асуултад хариулаарай.

Халамцуухан мазаалай

Мазаалай нь говь цөлд амьдардаг дэлхийн цорын ганц баавгай бөгөөд зөвхөн Монголын говьд байдаг байна. Мазаалайн эм нь эвш, бамбарууш нь алманцаг гэсэн сонин нэртэй. Хоёр жил болж байж төрдөг. Тэгэхдээ голдуу ихэрлэдэг юм гэсэн. Агуй хонгил, хулсан ширэнгэ, сухайн төгөл доогуур үүр ноохойгоо засна. Өвөл тэндээ ичдэг. Сүүдэр олохгүй бол хулс зэгс овоолж овоохой босгочихдог. Өдрийн халууныг овоохойдоо хэвтэн өнгөрөөж, үдшээс үүр цайтал гөрөөлнө.

Мазаалай устаж байгаа амьтан. Шүднээсээ олонгүй баавгай үлдсэн гэж эрдэмтэд тооцоолжээ. Мазаалайн тоо толгой цөөн боловч ургамлын гаралтай идэш тэжээлээр зонхилон хооллож, жижиг баянбүрдийг түшиж амьдардаг нь экосистемд чухал ач холбогдолтой. Хөхтөн амьтдын сэг зэмээр хооллодог тул байгальд ариутгагчийн үүрэг гүйцэтгэхээс гадна хөрсний ус ойр газар малтаж ус гаргадаг учир хавтгай зэрэг говийн бусад хөхтөн амьтдыг усаар хангахад чухал үүрэгтэй.

Говийн байнгын үзэгдэл их ган ундаалдаг ус булгийг нь ширгээдэг. Тэр ангаж үхнэ. Зарим жил тэндхийн хөрснөөс зээргэнэ ч цухуйхгүй. Тэр яс мэрсээр байгаад өлбөрч үхдэг. Тэд ийнхүү ядарч зүдэрч амьдарч байгаа билээ. Мазаалай цөөхөн. Тийм атлаа говьд хааяа нэг тааралдахаараа бие биеэ барьж иднэ гээч. Салгалалдан архиралдаж бие биенээ айлгах гэж байдгаараа ярзайлдан орилолдог. Тэгээд л ноцолдчихно. Нэг нь дийлж, нөгөөдөх нь дийлдэх нь мэдээж. Дийлдсэн нь биеэ суллан сарвуугаа өргөн гөлөлзөж бууж өгдөг. Тэд бууж өгснийгөө алж байж санаа нь амардаг. Алаад зогсохгүй гэдэс дотрыг нь гаргаж иддэг гэсэн.

Говийн баавгай их унтамхай. Тэгэхээс ч аргагүй. Цөлийн мансуурсан халуунд өөр юу ч хийх билээ? Их ган нүүрлэж, идэш тэжээлгүй болбол зунаар ичээлнэ. "Уруудахад унтаж идэх" гэж хүмүүс бие биеэ хэлдэг. Энэ үг баавгайд ч тохирмоор санагдана. Мазаалай намар болохоор хармагийн жимс их иднэ. Говийн жимс тун исгэлэн. Бараг мөчир дээрээ бэлэн болчихсон дарс л гэсэн үг. Мазаалай өлөн элгэн дээрээ хармаг идсээр байгаад согтчихдог байна. Согтуурч мансуурах нь сайхан мэт "санагдах" тул хүн архинд ордогтой адил хармагт орчихно. Тэр мөнхийн согтуу найгана. Үе үеээн энэхүү одой баавгай хоёр гараараа цээжээ уран овоохойгоо тойрон гүйж яваа харагддаг гэнэ. Халамцуу мазаалай тархиа шааж, өөрөө өөртөө агсам тавина. Бас нохой харвал чулуу шидэж дөвчигнөнө. Тэгснээ учиргүй их орилж хүүхэд шиг уйлдаг аж. Элчилгүй их элсэн цөлд балран сөнөж буй тавиландаа бачимдан давчиддаг ч байж мэдэх юм.

Говьд байгаа бүхнийг зөвхөн сөнөх тавилан хүлээж байдаг нь аймшигтай шүү.

\Ж.Мягмарсүрэн\

1. Мазаалай зуны халуун өдөр, шөнийг хэрхэн өнгөрөөдөг тухай баримт мэдээллийг ялган бичнэ үү? /2 оноо /

.....
.....

.....

2. Дараах үгсийн утгыг тайлбарлана уу. \2 оноо\

Хулжих:

Бэлзэг:

3. Мазаалайн хорогдож байгаа шалтгаан юу вэ? \2-ыг бичнэ үү\ /2 оноо/

.....

.....

.....

.....

4. Мазаалайн согтохоороо хийдэг үйлдлүүдээс бичнэ үү.\2 оноо\

.....

.....

5. Мазаалайн байгаль болоод бусад амьтдад тус болохуйц гурван гол шалтгааныг бичнэ үү? /2 оноо /

.....

.....

.....

6. Зохиолыг гол дүртэй нь зөв харгалзуулаарай. \5 оноо\

- | | |
|--------------------------------------|---|
| 1. “Үрэгдсэнийг хүлээгч” \өгүүллэг\ | а. Сэнгээ, Алимаа, Давст, Пагма |
| 2. “Далан худалч” \хошин жүжиг\ | б. Нямаа, Жамьяан, жаал хүү, их хүү |
| 3. “Усны эргүүлэг ба борзооны явдал” | в. Илбэчин, багш, хүү, эмгэн, өвгөн |
| 4. “Шидэт хүүрийн үлгэр” | г. Полифем, Хэнчбиш, Циклоп, Перимед |
| 5. “Одиссей” \их туульс\ | д. Цэвэгдорж, Жанцан, Лодойсамбуу, Сэмбэн |

7. Үндэсний бичгээс кирил бичигт хөрвүүлээрэй.

1. $\frac{1}{x^2} - \frac{1}{x^3}$ хэсгийг хамгаалах талаар
 2. $\frac{1}{x^2} - \frac{1}{x^3}$ хэсгийг хамгаалах талаар
 3. $\frac{1}{x^2} - \frac{1}{x^3}$ хэсгийг хамгаалах талаар
 4. $\frac{1}{x^2} - \frac{1}{x^3}$ хэсгийг хамгаалах талаар
 5. $\frac{1}{x^2} - \frac{1}{x^3}$ хэсгийг хамгаалах талаар

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

ХОЁРДУГААР ХЭСЭГ: БИЧИХ ЧАДВАРЫГ СОРЬСОН ДААЛГАВАР

Дээрх “Халамцуухан мазаалай” эхэд устаж, цөөрч байгаа мазаалай баавгайн талаар өгүүлжээ. “Халамцуухан мазаалай” эхийн найруулгын арга хэлбэрийг ашиглан өөрийн харж, сонсож байсан дархан цаазат амьтдыг хамгаалах талаар “Устаж буй амьтдыг хамгаалахад бидний оролцоо” сэдвээр 150- 200 үгэнд багтаан эх зохион бичээрэй. Бичихдээ дараах агуулгын бүтцийг ашиглаж болох юм.

- Эхлэл хэсэг : - Устаж мөхөж буй амьтдын талаар мэдээлэл өгөх
- Гол хэсэг : - Тухайн амьтад ямар шалтгааны улмаас цөөрч байгаа талаар батлан бичих
- Төгсгөл хэсэг : - Эдгээр амьтдыг хайрлаж хамгаалах, өсгөж үржүүлэхэд хүмүүсийн үүрэг оролцооны талаар өөрийн үзэл бодлыг дүгнэн бичиж төгсгөх

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....